



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ -ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М. Батсуурь Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М. Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн аудитор: С. Эрдэнэчимэг Утас: 9902-3656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16-17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.03.15 № УВА-2023/04/МА-СТА-ОМА
танай -ны № -т

“ШИНЭ-УЛААНГОМ” ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.СУМЪЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “ШИНЭ УЛААНГОМ” ОНӨААТҮГ -ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“ШИНЭ-УЛААНГОМ” ОНӨААТҮГ –ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг гараагүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

0200200708

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 21-р сарын 3	2022 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	661,310.16	416,001.70
1.1.2	Дансны авлага	6,034,100.00	727,361.00
1.1.4	Бусад авлага	0.00	2,023,185.90
1.1.6	Бараа материал	3,683,000.00	2,295,000.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,378,410.16	5,461,548.60
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,144,064,230.74	1,996,515,426.81
1.2.2	Биет бус хөрөнгө	375,000.00	657,219.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,144,439,230.74	1,997,172,645.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,154,817,640.90	2,002,634,194.59
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	630,858,900.00	
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	205,841.80
2.1.1.3	Татварын өр	45,848,599.62	47,812,603.65
2.1.1.4	НДШ-ийн өглөг	300,912.00	738,235.22
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,865,360.01	11,616,160.01
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	684,873,771.63	60,372,840.68
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	528,661,514.01
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	528,661,514.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	684,873,771.63	589,034,354.69
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	3,052,500,000.00	3,052,500,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	72,000,000.00	72,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,654,556,130.73	-1,710,900,160.10
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,469,943,869.27	1,413,599,839.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2,154,817,640.90	2,002,634,194.59

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	368,023,000.00	434,785,274.14
2	Борлуулалтын өртөг	240,146,274.00	
3	Нийт ашиг (алдагдал)	127,876,726.00	
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	81.80	6,150,465.90

9	Борлуулалт, маркетингийн зардал	400,000.00	3,248,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	226,556,371.00	495,087,016.01
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		2,113,400.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-99,076,645.59	-59,512,675.97
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-99,076,645.59	-59,512,675.97
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-99,076,645.59	-59,512,675.97
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-99,076,645.59	-59,512,675.97
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	427,816,200.00	489,134,482.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	423,966,200.00	481,130,682.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,850,000.00	8,003,800.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	427,558,087.02	396,249,104.46
1.2.1	Ажиллагчдад төлсөн	86,257,400.00	97,852,311.79
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	25,494,900.00	28,169,904.73
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	17,193,500.00	37,125,330.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	150,574,700.00	169,535,687.75
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	0.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00



1.2.7	Татварын байгууллагад төлсөн	69,558,200.00	46,086,110.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,998,400.00	10,024,800.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	68,480,987.02	7,454,960.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	258,112.98	92,885,377.54
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө буруулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		4,759,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	4,759,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-4,759,900.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	88,370,786.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	88,370,786.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-88,370,786.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	258,112.98	-245,308.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	403,197.18	661,310.16
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	661,310.16	416,001.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,654,556,130.73	1,469,943,869.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	3,168,646.60	0.00
3	Залруулсан үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,651,387,484.13	1,473,112,515.87
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	-59,512,675.97	-59,512,675.97
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,710,900,160.10	1,413,599,839.90

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны	
				төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	мян.төг	369,828.0	432,820.1	434,785.20
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	мян.төг	491,918.8	507,755.9	500,448.40
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	мян.төг	91,905.6		
4	Үндсэн цалин	мян.төг	91,905.6	108,116.4	
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	мян.төг	12,408.0	13,514.4	
6	Байр ашиглахтай холбоотой зардал	мян.төг	159,674.7		
7	Гэрэл цахилгаан	мян.төг	43,690.8	43,200.0	
8	Түлш, халаалт	мян.төг	7,802.4	101,181.5	
9	Цэвэр ,бохир ус	мян.төг	108,181.5	7,572.0	
10	Хангамж, бараа материалын зардал	мян.төг	3,570.0		
11	Бичиг хэрэг	мян.төг	675.0		
12	Гэрэлтүүлэг цахилгааны засвар материал	мян.төг	900.0		
13	Сантехник сэлбэг хэрэгсэл	мян.төг	900.0		
14	Хогийн сав	мян.төг	740.0		
15	Дулаалгын материал	мян.төг	250.0	3,611.0	
16	вриусны программ	мян.төг	105.0		
17	ТУЗ-н зардал	мян.төг	7,738.4	16,544.4	
18	Сарын суурь	мян.төг			
19	Интернет төлбөр	мян.төг	2,040.0	2,040.0	

20	Цэвэрлэгээний материал	мян.төг	3,487.3	3,487.3
21	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	2,200.0	
22	Ажлын хувцас	мян.төг	2,200.0	1,140.0
23	Урсгал засвар	мян.төг	6,720.0	2,500.0
24	Хог халваргүйжүүлэлт	мян.төг	6,320.0	6,320.0
25	Төлбөр хураамж	мян.төг	12,038.4	
26	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс/гадаад/	мян.төг	1,800.0	
27	Банкны зардал	мян.төг	240.0	2,640.0
28	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	мян.төг	160,118.4	160,118.4
29	Хөрөнгийн даатгал	мян.төг	9,998.4	10,024.8
30	Зар сурталчилгаа	мян.төг	420.0	420.0
31	Газрын төлбөр	мян.төг	720.0	720.0
32	ҮХХ-ийн татвар	мян.төг	13,988.0	11,895.7
33	Нийгэм хамгааллын зардал	мян.төг	4,810.0	4,810.0
34	Түлээ нүүрсний хөнгөлөлт	мян.төг	2,200.0	
35	Нэг удаагийн буцалтгүй	мян.төг	1,500.0	
36	Эрүүл мэндийн үзлэг	мян.төг	150.0	
37	Тэмдэглэлт баяр	мян.төг	960.0	
38	Хөрөнгө худалдан авах	мян.төг	3,760.0	7,900.0
39	Компьютер	мян.төг	2,560.0	
40	Сандал шүүгээ	мян.төг	1,200.0	
41	Мэдээлэл түгээх видео дэлгэц	мян.төг		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ нь “Улаангом сумын задгай талбайд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж иргэдийн тохилог дулаан хямд түрээсийн ажлын байраар хангах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Түрээсийн орлого
- ✓ Гадаад, дотоод худалдаа эрхлэх
- ✓ Нийтийн хоол

3.2 “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн ерөнхий болоод тусгай бодлогод тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна. Иймээс НББОУС 8-д тусгасан бодлогын өөрчлөлтөд нийцэх үйл явдал үүсээгүй болно.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

“Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын 2022 оны жилийн санхүүгийн байдлын тайлан дахь нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 152,183.5 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	661.3	416.0	-245.3
Авлага	6,034.1	2,750.5	-3,283.6
Бараа материал	3,683.0	2,295.0	-1,388.0
Үндсэн хөрөнгө	2,144,064.2	1,996,515.4	-147,548.5
Нийт хөрөнгө	2,154,817.6	2,002,634.1	-152,183.5
Өр төлбөр	684,873.8	589,034.3	-95,839.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,469,943.8	1,413,599.8	-56,344.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,154,817.6	2,002,634.1	-152,183.5

Увс аймгийн “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайланд толилуулсан хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид гарсан өөрчлөлтийн материаллаг хэмжээг нарийвчлан толилуулбал дараах байдалтай байна.

Авлага дансны үлдэгдэл 2,750.5 мянган төгрөг болж 3,283.6 мянган төгрөгөөр буюу 54 хувиар буурсан байна. Уг бууралтад түрээсийн авлагын эхний үлдэгдлийн авлага барагдуулалт, тайлант хугацааны орлогоо бүрэн хураасан үйл явдал голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,295.0 мянган төгрөг болж 1,388.0 мянган төгрөгөөр буюу 38 хувиар буурсан байна. Тайлант хугацаанд 11,461.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж 12,849.7 мянган төгрөгийн зарцуулалтыг НББОУС 2-д тусгасан аргуудаас өөрийн байгууллагын бараа материалын бүртгэлийн бодлогод тусгасан ЭАЭЗ аргаар бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 147,548.5 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна. Тайлант хугацаанд НББОУС 16, НББОУС 38-ын дагуу хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцсэн 4,759.9 мянган төгрөгийн өртөг бүхий эргэлтийн бус хөрөнгийн анхдагч хэмжилт, дараа үеийн хэмжилтийн хувьд барилга байгууламжийн ангилалд дахин үнэлгээний загвар, тавилга эд хогшил ба компьютер бусад хэрэгслийн ангилалд өртгийн загвараар тус тус толилуулсан байна. Тайлант хугацаанд 151,648.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоны 77 хувь нь барилга байгууламжийн элэгдэл байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 589,034.3 мянган төгрөг болж 95,839.5 мянган төгрөгөөр буюу 14 хувиар буурсан байна. Өр төлбөрийн хувьд санхүүгийн тайлангийн аудитаар алдааны залруулгыг дараах ангилалд хийсэн болно. Үүнд дансны өрийн үлдэгдэл байдлаар 2014 оноос хойш үүссэн Их барилга ХХК-д өгөх өр төлбөр нь уг ангилалд хугацааны хувьд тохирохгүй байгаа учир бусад урт хугацаат өр төлбөрөөр 528,661.5 мянган төгрөгийг шилжүүлэн ангилав. Мөн татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн өрийн эхний үлдэгдэлд үүссэн зөрүүг тооцооны үлдэгдлийн баталгаанд үндэслэн 3,168.6 мянган төгрөгийн алдааны залруулгыг НББОУС 8-ын буцаан мөрдөх горимоор залруулга хийсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1,413,599.8 мянган төгрөг болж 56,344.0 мянган төгрөгөөр буюу 4 хувиар буурахад хуримтлагдсан ашиг 3,168.6 мянган төгрөгийн алдааны залруулгаар өссөн, тайлант хугацааны 59,512.6 төгрөгийн алдагдлын дүнгээр буурсан явдал нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоолоор Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.



Тайлант оны нийт орлогыг 432,820.1 мянган төгрөг, нийт зардалыг 507,755.9 мянган төгрөг, (74,935.8) мянган төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 440,935.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 500,448.4 мянган төгрөгийн зардал гарган, (59,512.6) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь түрээслэгчдийн байр ашиглалтын төлбөрөөс бүрджээ.

Нийт орлогын гүйцэтгэл 440,935.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2 хувиар өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 500,448.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 7,307.5 мянган төгрөг буюу 1.4% хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 59,512.8 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 15,423.0 мянган төгрөгийн дутуу байгаа нь түрээсийн орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийлгэсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2023 оны 02 дугаар сарын 15-аас 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь, аудитын менежер М.Бат-Амгалан нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Ариунтөгс Оршихуй аудит ХХК-д 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 467,102.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,671.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 500,448.4 мянган төгрөгийн 1 хувь буюу 5,004.5 мянган төгрөгөөс 80 хувиар 4,003.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үндсэн үйл ажиллагаанд шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж зардлыг гаргахгүй байх зэргээр зорилтот түвшний хүрээнд батлагдсан зардлыг хэмнэж ажилласан байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2, оруулаагүй 12 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогыг нарийвчлан тусгагдаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, үндсэн үйл ажиллагааны чиглэл болох түрээсийн үйл ажиллагааны орлогын бүртгэл, үйл ажиллагааны зардлын бүртгэлийг буруу бүртгэсэн байна. Иймээс байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай гэж үзлээ.

Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын захирлын тушаалаар ажилчдадаа олгосон 4,248.1 мянган төгрөгийн шагнал урамшуулал, түлшний хөнгөлөлт зэргээс нийт 253.0 мянган төгрөгийн НДШ, 334.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын шимтгэл суутган тооцоогүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.1.4-ээр заалт, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1, 16.1.4-ээр заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1-ээр заалтыг зөрчиж байна.

Нэр бүхий 5 ажилтны амралтын мөнгө 2,886.5 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй нь улмаас нийгмийн даатгалын тайлангаарх болон санхүүгийн байдлын тайланд тусгасан өрийн үлдэгдлийн зөрүү байна.

Иймд дээр асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийгмийн даатгалын хэлтэст албан бичиг хүргүүлэхээр болов.



4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын хувьд дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлтийн иж бүрдлийг анхаарах.

Цалин ба түүнтэй адилтгах зардал, нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын өрийн тооцоолол болон үлдэгдлийн баталгаажуулалтад анхаарах.

Үндсэн үйл ажиллагааны орлого болон зардлын ангиллыг үнэн зөв тодорхойлсон эсэхийг нягтлах.

Цахилгааны төлбөрийг байгууллагаас төлөөд дараа нь түүнийгээ түрээслэгч нараас үйл ажиллагааны бус орлого байдлаар бүртгэж хураан авах үйл явдал цаг хугацаандаа, үнэн зөв, иж бүрэн эсэхийг нягтлах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 868,916.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа.

- ✓ Богино хугацаат өр төлбөрийн ангилалд хамаарахгүй байгаа 528,661.5 мянган төгрөгийн дансны өрийг бусад урт хугацаат өр төлбөрт шилжүүлэн ангилсан.
- ✓ Үндсэн үйл ажиллагааны чиглэл түрээсийн үйлчилгээ үзүүлэх байгууллага учир борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансанд хуримтлуулсан 251,649.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаар ангилж шилжүүлсэн.
- ✓ Их барилга ХХК-д тайлант хугацаанд төлсөн 88,370.8 мянган төгрөгийн өр төлөлтийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардалд тусгасныг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зардал хэсэгт ангилав.
- ✓ ТУЗ-ийн 5 гишүүдийн цалингаас нийгмийн даатгалын шимтгэлийг 11.3 ба 9.3 хувиар суутгах байсныг жилийн турш 12.5 хувиар суутган 205.8 мянган төгрөгийг илүү суутгасныг цалингийн өглөгт, хувь хүний орлогын албан татварын өрийн үлдэгдэлд 28.7 мянган төгрөгийн залруулгыг хийсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхигдуулсан, андуурсан НББ-ийн алдаа	4	868,916.2	1	28.7	3	868,887.5	4	868,916.2				
Дүн	4	868,916.2	1	28.7	3	868,887.5	4	868,916.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Албан тушаалтны тоо		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



